



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/610

Булган сум

Г “Булган мээж” ОНӨХХК-тай гэрээ
байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Х/73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 2025-2026 оны халаалтын улиралд дулаан үйлдвэрлэх, түгээх, дамжуулах ажлыг хэвийн явуулахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн дэмжлэгийг буцаан төлөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулж олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Булган мээж” ОНӨХХК-тай зээлийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд) нарт үүрэг болгосугай.

3. Шаардлагатай мөнгөн хөрөнгө болох 1,745,000,000 (нэг тэрбум долоон зуун дөчин таван сая) төгрөгийг холбогдох хууль журмын дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс олгохыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010850